

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ  
ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /сая төгрөг /	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн %
<b>ЯАМНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ, ТӨРӨӨС ИРГЭДЭД ҮЗҮҮЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭГ ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭЛ ХИЙХ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН, ШУУРХАЙ, ЧИРЭГДЭЛГҮЙ ХҮРГЭХЭД ЧИГЛҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ</b>							
1.	Яамны төлөвлөгөөний 36. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, санал, зөвлөмж боловсруулна.	200	Судалгааны тоо-1, Зөвлөмжийн тоо-1	0	2	Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, санал, зөвлөмж боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан үнэлгээний хороонд хүргүүлсэн. Тус ажлыг СБТГ хариуцан хэрэгжүүлж байна.	-
2.	Яамны төлөвлөгөөний 37. Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх аргачлал боловсруулах, эрх зүйн орчныг бий болгоно.	-	Аргачлалын тоо	0	1	Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх аргачлал боловсруулах, эрх зүйн орчныг бий болгохоор судалж байна.	-
3.	Яамны төлөвлөгөөний 38. Төрийн байгууллагын үйлчилгээнд процессын дахин инженерчлэл, шинжилгээ хийнэ.		Байгууллагын тоо-2	0	2	Тус яамнаас Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Ухаалаг засаг 2 төсөл"-	-

						ийн 2026 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 2.1.11.2-д “Төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэл хийх” төслийн ажлын даалгаврыг боловсруулах чиглэлийг хүргүүлсэн. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын А/102 дугаар тушаалаар Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ээр дамжуулан үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дахин загварчлах, үе шатыг бууруулах талаар санал, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгээс гарсан үр дүнг Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан.	
4.	Яамны төлөвлөгөөний 39. Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ийг тархсан бүтцэд шилжүүлнэ.	-	Тархмал бүтцэд шилжсэн мэдээлэл хариуцагч байгууллагын тоо	0	3	- “Ухаалаг засаг 2 төсөл” -ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 2.2.2.2-т заасан “Бие даасан техникийн зөвлөх/ХУР систем”-ийн зөвлөх сонгон шалгаруулж, 2025 оны 04 сарын 04-ний өдрийн №2222 дугаартай гэрээ байгуулагдсан. - “Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-ийг тархсан бүтэц шилжүүлэх” зөвлөх үйлчилгээний ажлын явц болон гүйцэтгэгчийн тайланг хянан баталгаажуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тушаалын төсөл /бүрэлдэхүүн, удирдамж/-ийг мэдээллийн технологийн төсөл,	50

						хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтний хамт боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/188 дугаар тушаалаар батлуулсан. - “Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-ийг тархсан бүтэц шилжүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргжил арга зүйн дэмжлэг үзүүлэх техникийн зөвлөх И-Монгол академи УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ дээр биечлэн ажиллаж, ажлын даалгаврыг боловсронгуй болгох, харьцуулсан судалгааны ажил тус тус хийгдэж байна.	
5.	Яамны төлөвлөгөөний 40. Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт боловсруулна.	-	Хүргүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн тоо	0	12	Зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий 2022 оны А/25 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн тушаалыг шинэчлэн ЦХИХХС-ын 2025 оны А/55 дугаар тушаалаар батлагдсан. Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг isr.gov.mn цахим системээр авч байна. 2025 онд: 1. Гадаадын иргэнд оршин суух үнэмлэх хэвлэх киоск машины программ хангамжийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, 2025.01.03-ны өдөр 03/06 бичгээр Гадаадын иргэн, харьяатын газарт; 2. Газрын тосны бүтээгдэхүүн хангамжийн “mpetro.smartsolution”	100%

						<p>системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, 2025.02.04-ний өдөр "isr.gov.mn" системээр Ашигт малтмал газрын тосны газарт;</p> <p>3. Хууль зүйн туслалцааны төвийн хиймэл оюунд суурилсан хуулийн зөвлөгөө өгөх мобайл аппликэйшн хөгжүүлэх ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа 2025.02.17-ны өдөр цахим шуудангаар нэгтгэсэн албан хаагчид;</p> <p>4. Авто зогсоолын удирдлага, зохион байгуулалтын ухаалаг систем ба тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолттой танилцан, судлан үзэж, зөвлөмж бүхий хариуг 2025.02.18-ны өдөр 03/387 бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт;</p> <p>5. Тээврийн хэрэгслийн нэгдсэн удирдлагын систем (VIMS)-ийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, 2025.02.26-ны өдөр 03/466 бичгээр Зам тээврийн яаманд;</p> <p>6. Хүн амын ерхийн мэдээллийн сангийн мэдээллийн системийн /шинэчлэл/ ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа өгч, 2025.02.28-ны өдөр "isr.gov.mn"</p>
--	--	--	--	--	--	--

						<p>системээр Үндэсний статистикийн хороонд;</p> <p>7. Хоригдогсдын бүртгэл, хяналтын системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа өгч, 2025.05.16-ны өдөр "isr.gov.mn" системээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт;</p> <p>8. Түрээсийн орон сууцны цахим системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа өгч, 2025.05.17-ны өдөр "isr.gov.mn" системээр Төрийн орон сууцны корпорац ХХК-д;</p> <p>9. Агуулахын бүртгэлийн системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа өгч, 2025.05.17-ны өдөр "isr.gov.mn" системээр Зоонозын өвчин судлалын үндэсний төвд тус тус хүргүүлсэн.</p>	
6.	<p>Яамны төлөвлөгөөний 45. Цахим засаглалыг эрчимжүүлж, салбар бүрийн эрх зүйн орчны реформ хийнэ.</p>	100.0 Урсгал зардал	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	1	<p>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" А/01 дүгээр тушаалын хүрээнд "Цахим засаглалыг эрчимжүүлэх, салбар бүрийн эрх зүйн орчны реформ хийхэд хуулийн зөвлөх үйлчилгээ"-ний ажлын даалгаврыг боловсруулж, 2025.03.31-ний батлуулсан. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.14-ний өдрийн А/89 дугаар тушаалаар үнэлгээний</p>	70%

						хороо байгуулагдсан бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулагдсан. Тус тендер шалгаруулалтад шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул дахин зарлахаар ажиллаж байна.	
7.	"Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	-	Боловсруулсан баримт бичгийн тоо		1	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан "Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг шинэчлэн боловсруулж олон нийтээс санал авахаар 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр mddic.gov.mn цахим системээр байршуулсан.	70%
8.	Яамны төлөвлөгөөний 46. Цахим шилжилтийг салбар бүрд эрчимжүүлэхэд тухайн салбарын талаарх хөндлөнгийн анализ бүхий материал, нэвтрүүлэг, контент хийнэ.	80.0 Урсгал зардал	Контентын тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулж 2025.03.31-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Үйлчилгээ авах тендерийг зохион байгуулах 2025.04.30-ны өдрийн А/124 дугаартай үнэлгээний хорооны тушаалыг батлуулсан. 2025.06.02 өдөр тендерийг нээж үнэлгээ хийсэн. Зөвлөмжийг Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.	70%

9.	Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас (gov.mn)-ыг ашиглах заавар, аргачлалыг боловсруулж, батлуулах	-	Батлагдсан баримт бичгийн тоо	0	1	<p>Төрийн байгууллагын нэгдсэн вэб хуудсыг Нээлттэй мэдээллийн shilen.gov.mn-тэй уялдуулан хөгжүүлэхээр цахим хуудасны цэсний жагсаалт, байгууллагын бүтцийг эцэслэн боловсруулж 2025 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр И-Монголиа академи УТҮГ-т хүргүүлсэн. Мөн 2025 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр тус системийг гүйцэтгэгч Аствишн ХХК болон И-Монголиа академи УТҮГ-ын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж систем хооронд солилцох шаардлагатай мэдээллүүдийн жагсаалтыг талбар бүрээр нь гаргахаар шийдвэрлэж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. E-mongolia 5.0 төслийн хүрээнд Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсыг нэг загвар бүхий нэгдсэн удирдлагатай болгон хөгжүүлж, Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ "и-Монголиа"-тай холбох ажил хийгдэх бөгөөд вэб системийн хөгжүүлэлт 26 хувь, мобайл системийн хөгжүүлэлт 24 хувийн хэрэгжилттэй явж байна.</p>	80%
10.	<b>Яамны төлөвлөгөөний 54.</b> Кирил болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэг хийх, зөв бичих дүрмийн алдаа хянах программ нэвтрүүлнэ.	610.0	Нэвтрүүлсэн системийн тоо	0	1	Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс баталгаажуулсан “Дуаллайн” ХХК-ийн боловсруулсан “Алдаа шалгагч, бичиг хөрвүүлэгч” программ нь төрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглахад аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй	50%

						талаар ЗГХЭГ-ын 2025.04.17-ны өдрийн ХЭГ/1043 дугаар албан бичиг (Тагнуулын ерөнхий газрын даргын 2025.04.01-ний өдрийн ЗГХЭГ-ын тэргүүн дэд даргад хүргүүлсэн ТЕГ01/128 дугаар албан бичиг)-ээр ирсэн тул эрсдлийг бууруулахад чиглэсэн агуулга бүхий Ажлын даалгаврын төслийг боловсруулан хамтран батлахаар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албанд Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.28-ны өдрийн 02/975 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	
11.	Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-д нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	1	1	"Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-ийг тархсан бүтэц шилжүүлэх" зөвлөхийн бэлтгэсэн санал, зөвлөмжийг үндэслэн III-IV улиралд шаардлагатай өөрчлөлт оруулах төслийг боловсруулахаар төлөвлөсөн.	-
12.	Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	1	1	Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д нэмэлт, өөрчлөлтийн санал боловсруулахаар	70%

	тогтоох, үнэлгээ хийх журам"- д нэмэлт, өөрчлөлтийн санал боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.					Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/82 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалын хүрээнд тогтоолын төслийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг судлах ажил хийгдэж байна.	
13.	<b>Яамны төлөвлөгөөний 47.</b> "Дижитал-Аймаг, Дижитал- Хот" зөвлөмж боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	-	Баримт бичгийн тоо	0	1	"Дижитал-Аймаг, Дижитал-Хот" зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025.01.15-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулсан. "Дижитал аймаг-Дижитал хот" /Цахим аймаг- Ухаалаг хот/ зөвлөмжийн төслийг боловсруулж, 2025.02 дугаар сард тус ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн, Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэсэн.	80%
14.	<b>Яамны төлөвлөгөөний 47.</b> "Дижитал-Аймаг, Дижитал- Хот" зөвлөмжийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.	2,100. 0 Урсгал зардал	Зөвлөмж хэрэгжүүл сэн аймаг, дүүргийн тоо	2	8	"Цахим аймаг-Дижитал хот" зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх ажлын хэсгийн тушаалыг ЦХИХС-ын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд тус ажлын хэсэг 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хуралдаж ажлын хэсгийн төлөвлөгөөг баталсан. 2025 онд 7 аймагт "Цахим аймаг- Дижитал хот" зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулахаар худалдан авах ажиллагааны ажлын даалгаврыг	80%

						боловсруулан 2025.03.31-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2025.05.08-ны өдөр нээлттэй тендер зарлаж, 2025.05.29-ны өдөр тендерийг нээсэн. Тендерийг үнэлэх үйл ажиллагаа явагдаж байна.	
15.	Яамны төлөвлөгөөний 48. Төрийн программ хангамж, мэдээллийн системүүдийн кодын хувилбарыг бүртгэх, хадгалах систем нэвтрүүлнэ.	600.0 Урсгал зардал	Нэвтрүүлсэн системийн тоо	0	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/01 дүгээр тушаалын хүрээнд “Төрийн программ хангамж, мэдээллийн системүүдийн кодын хувилбар бүртгэх, хадгалах систем нэвтрүүлэх” үйлчилгээний ажлын даалгаврыг төслийг бэлтгэх 2025.02.21-ний өдрийн 03/327 тоот бичгийг Үндэсний дата төв УТҮГ-т хүргүүлэн, хамтран боловсруулж, 2025.03.31-ний батлуулсан. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.14-ний өдрийн А/89 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. 2025.05.29-ний өдөр ЦХИХХЯ/20250103050 дугаартай худалдан авах ажиллагааг нээж, зөвлөмжийг Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлээд байна.	80%

16.	Иргэд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглан төрийн бодлого, шийдвэр гаргалтад цахим хэлбэрээр санал өгөх боломжийг бүрдүүлнэ.	-	Нэвтрүүлсэн системийн тоо	0	1	Өргөдөл, гомдол, санал хүсэлт гаргах үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан иргэдэд үзүүлэх боломжийг бүрдүүлсэн.	100%
17.	Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил болгоход иргэн шууд хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.	-	Шалгах талбар нэмэх чиглэлээр бүртгэлийн журамд оруулсан нэмэлт, өөрчлөлт	0	1	“Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх” ажлын хүрээнд Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил болгоход иргэн шууд хяналт тавих боломжийг бүрдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	80%
18.	<b>Яамны төлөвлөгөөний 62.</b> Үндэсний программ хангамжийн их дэлгүүр систем нэвтрүүлнэ.	-	Нэвтрүүлсэн системийн тоо	0	1	Үндэсний программ хангамжийн их дэлгүүр систем нэвтрүүлэх ажил хүлээгдэж байна.	-
19.	<b>Яамны төлөвлөгөөний 12.</b> Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулна.	-	Цахим хэлбэрт шилжүүлсэн зөвшөөрлийн тоо	0	1	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад зориулж төрийн үйлчилгээг цахим нэг цонхны үйлчилгээгээр үзүүлэх e-business.mn цахим системээр 44 тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг цахимжуулж, 134 тусгай зөвшөөрлийг e-business.mn-д линкээр холбон байршуулсан.	80%

20.	<b>Яамны төлөвлөгөөний 49.</b> Шүүхийн салбарын цахим шилжилт төслийг хэрэгжүүлэх суурь судалгаа хийж зөвлөмж боловсруулна.	20.0 Урсгал зардал	Зөвлөмжийн тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан.	-
21.	<b>Яамны төлөвлөгөөний 68.</b> Олон нийтийн байгууллагуудын засаглалыг дэмжих нээлттэй платформ хөгжүүлнэ.	280.0 Урсгал зардал	Платформын тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан бөгөөд 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/93 тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдсан. Үйлчилгээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлан 2025.05.28-ны өдөр нээсэн. Тендерт оролцогчдыг хянан, үнэлэх ажиллагаа явагдаж байна.	80%
22.	<b>Яамны төлөвлөгөөний 50.</b> Төрийн үйлчилгээг хиймэл оюун ухааны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий “Ухаалаг E-Mongolia” системийг хөгжүүлнэ.	-	Хөгжүүлж, нэвтрүүлсэн хувилбар	E-Mongolia 4.0	E-Mongolia 5.0	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр нээлттэй тендер шалгаруулалт зарласан бөгөөд 2 оролцогч санал ирүүлсэн боловч шаардлага хангаагүй тул дахин зарласан. 2025.06.17-ны өдөр нээнэ.	-
23.	<b>Яамны төлөвлөгөөний 53.</b> Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программын нэгж лицензийн үнийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг Засгийн	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программын нэгж лицензийн үнийг бууруулахад чиглэсэн ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах 2025.01.20-ны өдрийн 01/128 тоот бичгийг ЗГХЭГ, ШСАА, ТЕГ, ТХААГ, Нийтийн төв, ҮДТ-д	90%

	<p>газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.</p>					<p>хүргүүлсэн. Улмаар ажлын хэсгийг ЦХИХХСайдын 2025.02.12-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нөхцөл байдлын судалгаа авах талаарх 2025.01.22-ны өдрийн 01/153 тоот бичгийг мэдээлэл хариуцагч 60 гаруй байгууллагад хүргүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 5,671 байгууллагын 17% буюу 939 байгууллага судалгаанд хамрагдсан бөгөөд 49,017 компьютер ашиглаж байгаагийн 88.5% нь, мөн 2,261 сервер ашиглаж байгаагийн 79% нь тус тус Майкрософтын корпорацын бүтээгдэхүүнийг сонгон ашиглаж байна. Түүнчлэн төсвийн 68 байгууллагаас сүүлийн 2 жилийн хугацаанд Майкрософтын 6 төрлийн 138,164 ширхэг лицензийг нийт 5.5 тэрбум төгрөгөөр худалдан авсан байна.</li> <li>• Кибер аюулгүй байдлын зөвлөлтэй хамтран Монгол дахь АНУ-ын Элчин сайдын яамаар дамжуулан Майкрософт корпорацын Казакстан, Болгар, Румын, Египет, Турк Улсад байрладаг бүс нутгийг хариуцсан төвүүдийн мэргэжилтнүүдтэй холбогдон ажиллаж, мэдээллийн</li> </ul>	
--	--	--	--	--	--	---	--

						<p>аюулгүй байдлыг бүрэн хангах, бүх өгөгдлийг МУ-ын нутаг дэвсгэр дээр хадгалах шийдэл, оюуны өмчийн зөрчилгүй программ хангамж ашиглах, хамтран ажиллах талаар зөвлөлдсөн. Майкрософт корпорац МУЗГ-ын хэрэгцээ, шаардлагад нийцсэн шийдэл санал болгохоор урьдчилсан байдлаар хүлээн зөвшөөрсөн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажлын хэсгийн 2025.05.13-ны өдрийн хурлаар Майкрософт корпорацтай цахим уулзалт хийж, харилцан ойлголцлын санамж бичгийн болон нууцлалын гэрээний төслийг эцэслэн боловсруулсан.</li> <li>• Лицензийг нэгдсэн зохион байгуулалттайгаар “Цахим дэлгүүр”-т байршуулахад шаардлагатай техникийн тодорхойлолт хамтран боловсруулах 2025.03.21-ний өдрийн 03/632 тоот бичгийг ҮДТ-д хүргүүлэн хамтран ажилласан. Улмаар 2025.05.12-ны өдрийн байдлаар ТХААГ-тай хамтран 12 төрлийн лицензийг ерөнхий гэрээгээр худалдан авах боломжийг бүрдүүлсэн.</li> <li>• Явцын тайланг 2025.05.20-ны өдрийн 01/1195 тоот бичгээр</li> </ul>
--	--	--	--	--	--	--

						Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж 2025.05.28-ны Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурлаар танилцуулагдсан.	
24.	<p><b>Яамны төлөвлөгөөний 55.</b> Технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай мэргэжилтэн бэлтгэх, шаардлагатай түвшинд шалгалтын дотоод систем нэвтрүүлэх, хүний нөөцийн нэгдсэн бүртгэлийн систем бий болгоно.</p>	-	Системийн тоо	0	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/01 дүгээр тушаалын хүрээнд “Технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай мэргэжилтэн бэлтгэх, шаардлагатай түвшинд шалгалтын дотоод систем нэвтрүүлэх, хүний нөөцийн нэгдсэн бүртгэлийн систем бий болгох” үйлчилгээний ажлын даалгаварт тусгах санал авах 2025.02.27-ны өдрийн 03/483 тоот бичгийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, харьяа УТҮГ-уудад хүргүүлж, ирүүлсэн хариуг нэгтгэн боловсруулж, 2025.03.31-ний батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.14-ний өдрийн А/89 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. 2025.05.29-ний өдөр ЦХИХХЯ/20250103041 дугаартай худалдан авах ажиллагааг нээж, зөвлөмжийг Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлээд байна.	80%

25.	<b>Яамны төлөвлөгөөний 51.</b> Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шаардлагатай системүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлыг зохион байгуулах.	-	Системийн тоо	0	2	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шаардлагатай системүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлыг зохион байгуулахаар судалж байна.	-
26.	<b>Яамны төлөвлөгөөний 52.</b> Блокчейн технологи ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг баталгаажуулах ажлыг зохион байгуулна.	850.0 Урсгал зардал	Блокчейн технологи нэвтрүүлсэн бүртгэлийн үйлчилгээний тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан бөгөөд 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/96 тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдсан. "Блокчейн технологи ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг баталгаажуулах" үйлчилгээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлан 2025.05.28-ны өдөр нээсэн. Тендерт оролцогчдыг хянан, үнэлэх ажиллагаа явагдаж байна.	80%
27.	<b>Яамны төлөвлөгөөний 56.</b> Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэл хөтөлнө.	-	Бүртгэсэн мэдээллийн сангийн тоо	0	45	Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн системийг хэрэглээнд нэвтрүүлсний дараа III-IV улиралд бүртгэл хөтөлх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулахаар төлөвлөсөн.	-
28.	<b>Яамны төлөвлөгөөний 57.</b> Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэнэ.	-	Их өгөгдлийн (big data) сан үүсгэх	0	10	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024.11.15-ны өдрийн А/51 дугаар тушаалаар Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий	90%

			гүйцэтгэлийн хувиар		<p>Ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийн дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <p>-Хүний хувийн мэдээлэлд хамаарах 35 төрлийн мэдээлэл, хуулийн этгээдэд хамаарах 14 төрлийн мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох арга, аргачлалын хамт И-Монгол академи УТҮГ-т хүргүүлсэн.</p> <p>-Нийгмийн даатгалын мэдээллийн сан, Нийгмийн халамжийн мэдээллийн сан, Хүн амын өрхийн мэдээллийн сан, Мал тооллогын мэдээллийн сан, Бизнес регистрийн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг тус тус мэдээлэл хариуцагчдаас гаргуулан авах, мета-шинжилгээ хийх ажлыг зохион байгуулсан.</p> <p>-Өгөгдлийг 5 төрөл (Hashed keys, Masking, Obfuscation, Generalization, Perturbation)–өөр тодорхойлох боломжгүй болгон хувиргах хэрэгсэл, хувиргасан өгөгдлийг нууцлалтайгаар ХУР системээр дамжуулах сервисийг тус тус хөгжүүлж хөдөлмөр, халамж, статистик, даатгалын мэдээллийн сан хариуцсан 3 байгууллагад туршилтаар суурилуулж, заавар гарын авлагаар хангаж ажилласан.</p> <p>-“И-Монгол академи” УТҮГ-ын төлөөлөлтэй хамтран Үндэсний статистикийн хороо, Нийгмийн</p>
--	--	--	---------------------	--	--

						<p>даатгалын ерөнхий газрын Мэдээллийн технологийн төв дээр 2025 оны 05 сарын 27-28-ны өдрүүдэд ажиллаж, өгөгдлийг хувиргах, нууцлан дамжуулах явцад гарсан эх кодын алдааг засварлах, турших ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>-Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх дэд бүтцийг бэлдэх ажлын хүрээнд Үндэсний дата төв дээр 500GB санах ой бүхий нөөцийг үүсгэсэн.</p>	
29.	Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх платформ хөгжүүлнэ.	-	Нэвтрүүлсэн платформын тоо	0	1	<p>Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгсэл, хүний нөөцийн тооцоо, судалгаа хийх арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлаж, гэрээ байгуулах мэдэгдлийг шалгарсан оролцогчид хүргүүлсэн.</p>	70%
30.	Яамны төлөвлөгөөний 58. Хүн, хуулийн этгээдийг төрийн мэдээлэл сопилцооны систем (ХУР)-д	-	Шинээр холбогдсон хүн,	0	55	<p>2025 оны эхний хагас жилийн байдлаар "ХУР" системд төрийн 172, хувийн хэвшлийн 462 байгууллага, нийт 634 байгууллага холбогдсон.</p>	100%

	холбох ажлыг зохион байгуулна.		хуулийн этгээдийн тоо				
31.	Яамны төлөвлөгөөний 59. Хүн, хуулийн этгээдийг танилт, нэвтрэлтийн систем (ДАН)-д холбох ажлыг зохион байгуулна.	-	Шинээр холбогдсон хүн, хуулийн этгээдийн тоо	0	50	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар Танилт, нэвтрэлтийн нэгдсэн систем (ДАН)-д төрийн 98 байгууллагын 188, хувийн 276 байгууллагын 325 систем бүртгэлтэй 2,220,683 иргэн байна.	100%
32.	Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-д холбогдох үйлчилгээ (сервис)-ний тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Шинээр нийлүүлсэн сервисийн тоо	810	820	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 196 дугаар тогтоолоор баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 85 сервис үйлчилгээг шинээр хөгжүүлэн, холбох ажлыг зохион байгуулж, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 855 сервис үйлчилгээ холбогдсон.	100%
33.	Яамны төлөвлөгөөний 60. Сэлгэн ажиллах /high availability/ дата төвийн тоног төхөөрөмжийн нөөцийг бий болгоно	9,557.800 Улсын төсөв	Хэрэгжилт ийн хувь	0	100	Үндэсний дата төв УТҮГ-аас Сэлгэн ажиллах нөөц төвд шаардлагатай сервер, сүлжээ, хадгалах төхөөрөмж зэрэг 10 төрлийн 128 ширхэг техник хэрэгслийн тодорхойлолтыг боловсруулсан ирүүлсний дагуу "Сэлгэн	70%

						ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх” ЦХИХХЯ/20250102135 дугаар бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.	
34.	Үндэсний дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	Ухаал аг Засаг 20,310 .00	Үндэсний дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадал, хувиар	50	100	Үндэсний дата төв УТҮГ-аас дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн аюулгүй байдлын 20 төрлийн 102 ширхэг техник хэрэгслийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан ирүүлсний дагуу “Ухаалаг засаг 2 төсөл”-ийн хүрээнд “Үндэсний дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх” 2.2.1.1 дугаартай төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, үнэлэх ажил хийгдэж байна.	70%
35.	Нийтийн мэдээлэл хариуцагч байгууллага хуульд нээлттэй байхаар заасан мэдээллийг өөрийн цахим хуудаст байршуулсан эсэхэд үнэлгээ хийнэ.	-	Үнэлгээний тоо	0	16	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу цахим хуудсандаа нээлттэй байршуулах 67 төрлийн мэдээлэлд үнэлгээ хийж "Шилэн Индекс"-ийг системд нийтэлсэн. 2025 оны I улирлын байдлаар нийт 1135 тайлан илгээж, 1126 байгууллага үнэлэгдээд байна. "Шилэн Индекс"-ийн тайлан ирүүлсэн байгууллагын үр дүн: Төрийн захиргааны төв байгууллага 92.61% (Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газар болон 11 яам), Төрийн захиргааны байгууллага 79.61% (23	100%

						агентлаг), Нийслэлийн Засаг Даргын тамгын газар 55.59% (6 ЗДТГ), Нутгийн захиргааны байгууллага 75,84% (14 аймаг) гэсэн тус тус үзүүлэлттэй байна. Тус яам 2025 оны 1 дүгээр улирлын "Шилэн Индекс"-ийн тайланг илгээж 97,96% үнэлэгдсэн байна. Мөн салбар байгууллагуудын ирүүлсэн тайлангийн үнэлэгдсэн хувь:Харилцаа холбооны зохицуулах хороо 98%, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар 96%, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК 95%, Үндэсний дата төв 89% И-Монгол академи УТҮГ 89%-тай тус тус үнэлэгдсэн. Нээлттэй мэдээллийн нийт 45 төрлийн 970,355 мэдээллийг дор дурдсан чиглэлээр байршуулж, 15,784,843 удаагийн хандалтыг аваад байна.	
36.	<b>Яамны төлөвлөгөөний 41.</b> “Тусгай дугаар 112”-ын үйл ажиллагаанд шаардлагатай технологийн шийдлийг боловсруулж, нэвтрүүлэх нөхцөлийн судалгаа хийнэ.	100.0 Урсгал зардал	Судалгааны тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, үнэлгээний хороонд хүргүүлсэн.	80%
37.	<b>Яамны төлөвлөгөөний 61.</b> Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв /11-11/ болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сан,	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Иргэд, олон нийттэй харилцах төв “11-11”-ийн мэдээллийн системийг мэдэгдэл хүргэх системтэй холбож, улмаар иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдол, санал,	100%

	<p>мэдээллийн системийг нэгтгэх асуудлыг судалж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.</p>					<p>хүсэлтийн шийдвэрлэлтэд мэдэгдэл хүргэдэг болсон.</p> <p>-Засгийн газрын "Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын систем"-д 11-11, 101, 102, 103, 105 дугааруудад ирүүлсэн дуудлага, түүний төрөл, шийдвэрлэлтийн статистик мэдээллийг "дашбоард" хэлбэрээр харах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>-Иргэдийн асуултад хариулах, хууль эрх зүйн зөвлөмж өгөх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцыг мэдээлэх чадвартай хиймэл оюунд суурилсан "IVA" системийг "11-11.mn" веб хуудсанд холбож, "Харилцагчийн үйлчилгээний хиймэл оюуны виртуал ажилтан, операторын үйлчилгээ"-г 2025.03.31-ний өдөр ЗГХЭГ-тай хамтран нэвтрүүлсэн. Тус хиймэл оюун нь 2025.05.29-ны байдлаар 51,099 үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс 13,944 нь өргөдөл, гомдол бүртгэгдсэний 4,791 буюу 34%-ийг хүний оролцоогүй шийдвэрлээд байна. - Засгийн газрын "11-11", нийслэлийн "1800-1200" дугаарын үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сан, системийг нэгтгэх шийдлийг боловсруулж, "API" сервисийн хөгжүүлэлт хийх чиглэлийг 2025 оны 02/1204 бичгээр И-Монгол академид хүргүүлэн, хөгжүүлэлтийн ажлыг</p>	
--	--	--	--	--	--	---	--

						<p>эхлүүлсэн. Үүнтэй холбогдуулан ЗГХЭГ, НЗДТГ, Иргэд олон нийттэй харилцах төв, Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төв, И-Монгол академи УТҮГ, ERP систем хөгжүүлэгч байгууллагууд болон тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэх байгууллагуудтай нийт 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, ажлын хэсэг байгуулах төслийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2025.05.27-ны өдрийн 175 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан, III дугаар улиралд багтаан дуусгах үүргийг өгсөн. Мөн Тус “11-11” төвд иргэдийн гадаад улсаас хийх дуудлагыг хүлээх авах боломжийг судалж, холбогдох саналыг 2025 оны 01/613 тоот бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>□ Явцын тайланг 2025.05.20-ны өдрийн 01/1195 тоот бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Улмаар 2025.05.28-ны Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурлаар танилцуулагдсан.</p>	
38.	<p><b>Яамны төлөвлөгөөний 42.</b> Камерын хяналтын нэгдсэн систем бий болгоход шаардлагатай тоног төхөөрөмжийн нөхцөл шаардлагыг тодорхойлох суурь судалгаа хийж</p>	-	Судалгааны тоо	0	1	<p>Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн “Танилцуулга хүргүүлэх тухай” 7/2857 дугаар албан бичгээр “улсын хэмжээнд нэгдсэн дугаарлалтын систем нэвтрүүлэх, нийслэлд Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг өргөтгөх, орон нутагт</p>	50%

	стандартын төсөл боловсруулах					дуудлага хүлээн авах ажиллагааг Телекамерын хяналтын дэд төвтэй уялдуулан зохион байгуулах” ажлын Техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулахад шаардлагатай системийн шинжилгээ хийлгэх танилцуулга ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан холбогдох албан хаагчтай мэдээлэл солилцох зорилго бүхий уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан.	
39.	<b>Яамны төлөвлөгөөний 63.</b> Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (opendata.gov.mn)-ийн 3.0 хувилбарыг нэвтрүүлнэ.	400.0 Урсгал зардал	Нэвтрүүлсэн системийн тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан бөгөөд 2025.04.14-ний өдрийн А/88 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан. 2025.05.29-ны өдөр тендерийг нээж, үнэлгээ хийн, зөвлөмжийг Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлээд байна.	80%
40.	<b>Яамны төлөвлөгөөний 65.</b> Нээлттэй мэдээллийн “shilen.gov.mn” системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлнэ.	500.0 Урсгал зардал	Нэвтрүүлсэн хувилбар	2.0	3.0	Ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан бөгөөд 2025.04.14-ний өдрийн А/88 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан. 2025.05.29-ны өдөр тендерийг нээж, үнэлгээ хийн, зөвлөмжийг Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлээд байна.	80%

41.	<p><b>Яамны төлөвлөгөөний 66.</b> Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн систем хөгжүүлнэ.</p>	350.0 Урсгал зардал	Нэвтрүүлсэн хувилбар	1.0	2.0	<p>- "Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем хөгжүүлэх" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах төсвийн тооцоог гаргасан.</p> <p>- Дүгнэлт, зөвлөмжийн системийг суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэлтэй нэгтгэн "Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн систем хөгжүүлэх" ажлын даалгаврыг боловсруулсан.</p> <p>- "Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн систем хөгжүүлэх" ЦХИХХЯ/20250103043 дугаартай тендерийн хянах, үнэлэх ажиллагаа хийгдэж байна.</p>	80%
42.	<p>Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөрийн нэгдсэн бүртгэл хөтөлж, дүгнэлт боловсруулна.</p>	-	Бүртгэл хөтөлсөн тоо	1	1	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 219 дугаар тогтоолоор баталсан "Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтөлж, үнэлэх журам"-ын дагуу төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нийслэлийн төр захиргааны байгууллагаас 2025 онд хэрэгжүүлж буй нийтийн мэдээллийн дэд бүтэцэд хамаарах 28 төсөл</p>	90%

						хөтөлбөрийн мэдээллийг бүртгэн ажиллаж байна. Мөн Сангийн яамнаас Улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн мэдээллийг авч нэгтгэсэн.	
43.	Яамны төлөвлөгөөний 64. “Ухаалаг засаг 2” төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	Гадаадын зээл	Төсөл, хөтөлбөрийн тоо	10	20	Төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах ажлуудын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: <b>Баталгаажуулсан 22 гэрээ ба хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээлэл.</b> Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>✓ Дижитал шилжилтийн зохицуулагч зөвлөх С.Тэнгис, Дижитал Эдийн засгийн зохицуулагч зөвлөх Б.Тэмүүлэн нарын төслийн гэрээний хэрэгжилт 2025.06.13-ны өдөр дууссан.</li> <li>✓ “Ахмад настай иргэдийн дижитал ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд 4 хувь зөвлөх /Х.Саруул, Б.Оюумаа, Б.Энхмөрөн, Б.Оюунцэцэг, мөн нээлтийн үйл ажиллагаа /ХАҮТанхим/, гарын авлага боловсруулах төсөл /Очирпресс ХХК/ 2025.03.30-ны өдөр бүрэн хэрэгжиж дууссан.</li> <li>✓ Сангийн яамны Төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой дүрэм, журам, удирдамж, баримт бичгийг боловсруулах 3 зөвлөх /Б.Мөнхцэцэг, Д.Номингэрэл нарын гэрээ хэрэгжиж байна.</li> </ul>	100%

						<p>Б.Энхжаргалын гэрээ 2025.04.14 дууссан.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Төрийн худалдан авах ажиллагааны газрын Цахим худалдан авах ажиллагааны системд дэмжлэг үзүүлэх хувь зөвлөхийн Х.Хангай гэрээ хэрэгжиж байна.</li> <li>✓ Эдийн засаг, хөгжлийн яамны Цахим зөвшөөрлийн системийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх бие даасан 4 зөвлөх /Б.Цогбаярын гэрээ хэрэгжиж байна. Азбиллэг, Сарангэрэл, Амармөрөн 2025.01.21-02.25-ны өдрүүд хэрэгжиж дууссан/</li> <li>✓ ТХН-ийн санхүүгийн программ /Инфо систем ХХК/ хэрэгжиж байна</li> <li>✓ ТХН-ийн оффиссийн програм /Могоул ХХК/ хэрэгжиж байна</li> <li>✓ АТГ-ын "Мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем II үе шат төсөл"-ийн гэрээ /Ай ти зон ХХК/ хэрэгжиж байна.</li> <li>✓ ҮДТ-ийн "Монголын интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах" төслийн гэрээ /Мобинет ХХК/ хэрэгжиж байна.</li> <li>✓ Цахим шилжилтийн талаар хууль, тогтоомжийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах төслийн гэрээ /Эм эн агентлаг/ хэрэгжиж байна.</li> <li>✓ Цахим шилжилт хийхэд шаардлагатай дүрэм журмуудын хийдэл, зөрчлийг тогтоож, санал боловсруулах төслийн гэрээ /Ай ти инсайт/ хэрэгжиж байна.</li> </ul>	
--	--	--	--	--	--	--	--

						<ul style="list-style-type: none"> <li>✓ Хур/техникийн зөвлөх төслийн гэрээ /Магсаржав/ хэрэгжиж байна.</li> </ul> <p><b>Гэрээний төслийг боловсруулж буй 2 төслийн мэдээлэл. Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Дижитал эдийн засгийн зохицуулагч зөвлөх А.Анарын төслийн гэрээний төсөл боловсруулж байна.</li> <li>✓ Үүлэн тооцооллын үйлчилгээг ашиглах судалгаа Фибо клауд ХХК төслийн гэрээний төслийг боловсруулан баталгаажуулж байна.</li> </ul> <p><b>Олон Улсад болон олон нийтэд зарлагдан, Үнэлгээний хороотой холбоотой 5 төслийн мэдээлэл: Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Үндэсний дата төвийн Нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл ОУ-д нээлттэй зарлагдсан ба Дэлхийн банктай хамтран үнэлгээ хийгдэж байна.</li> <li>✓ Тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх төсөл ОУ-д нээлттэй зарлагдсан ба Дэлхийн банктай хамтран үнэлгээ хийгдэж байна</li> <li>✓ Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж төсөл ОУ-д нээлттэй зарлагдсан ба Дэлхийн банктай хамтран үнэлгээ хийгдэж байна</li> <li>✓ Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг</li> </ul>
--	--	--	--	--	--	--

						<p>сайжруулах дэд бүтцийг бий болгох төслийн үнэлгээ хийгдэж байна.</p> <p>✓ Засгийн газрын архивын тоног төхөөрөмж шинэчлэх төслийн үнэлгээ хийгдэж байна.</p> <p><b>Олон нийтэд нээлттэй зарлахаар төлөвлөж буй төслийн мэдээлэл: үүнд:</b></p> <p>✓ Цахим зөвшөөрлийн системийн тоног төхөөрөмж /ТББ бэлтгэгдэж байна/</p> <p>✓ Цахим худалдан авах ажиллагааны системийн сайжруулалт /ТББ бэлтгэгдэж байна/</p> <p><b>Санхүүжилттай холбоотой мэдээлэл:</b>  Ухаалаг засаг 2 төслийн татан авалт 4,000,000\$, нийт зарцуулалт 1,071,504\$ байна.  Эхэлсэн, дууссан огноо: 2025.01.02-2025.06.10  Биелэлтийн хувь: 85%.</p>	
44.	<b>Яамны төлөвлөгөөний 43.</b> Шил ажиллагааны хүрээнд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг сурталчилна.	18.0 Урсгал зардал	Арга хэмжээний тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.	-
45.	<b>Яамны төлөвлөгөөний 69.</b> Авто ослын баримтжуулалтын систем (ослын баримт баталгаажуулалтын платформ) хөгжүүлнэ.	300.0 Урсгал зардал	Платформын тоо	0	1	Авто ослын баримтжуулалтын систем (ослын баримт баталгаажуулалтын платформ) хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулж 2025.03.31-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, үйлчилгээ авах тендерийг зохион байгуулах 2025.04.15-ны өдрийн А/95 дугаартай үнэлгээний	80%

						хорооны тушаалыг батлуулсан. 2025.04.30-ны өдөр тендерийг зарлаж 2025.05.21 өдөр тендерийг нээж үнэлгээ хийгдсэн. Зөвлөмжийг Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.	
46.	<b>Яамны төлөвлөгөөний 71.</b> "Токенжуулсан хувьцаа" төслийг боловсруулна.	70.0 Урсгал зардал	Төслийн тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, үнэлгээний хороонд хүргүүлсэн.	100%
47.	<b>Яамны төлөвлөгөөний 44.</b> Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулна.	100.0 Урсгал зардал	Боловсруу лсан баримт бичгийн тоо	0	1	"Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулах" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, судалгааны ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан. Тус тендэрт 2 оролцогч материал ирүүлсэн боловч шаардлага хангах тендер ирүүлээгүй тул худалдан авах ажиллагааг дахин зарласан.	70%
48.	<b>Яамны төлөвлөгөөний 67.</b> Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслөөр ногоон дата төв байгуулах төслийн санал боловсруулна.	-	Төслийн саналын тоо	0	1	Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрших Хүннү хотод ногоон дата төв байгуулахаар ажлын даалгаврыг боловсруулан саналаа ЭЗХЯ-нд хүргүүлсэн.	100%

49.	<p><b>Яамны төлөвлөгөөний 98.</b> Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгсэл, хүний нөөцийн тооцоо, судалгаа хийнэ.</p>	100.0 Урсгал зардал	Судалгааны тоо	0	1	<p>-Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгслийн тооцоо, судалгаа хийх" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах төсвийн тооцоог гаргасан.</p> <p>-Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгслийн тооцоо, судалгаа хийх" ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-нд Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.</p> <p>-Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгсэл, хүний нөөцийн тооцоо судалгаа хийх" ЦХИХХЯ/20250203042 дугаартай үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах эрх олгох албан бичгийг хүргүүлсэн.</p>	80%
50.	<p><b>Яамны төлөвлөгөөний 70.</b> Иргэн гар утас, ухаалаг төхөөрөмжөө ашиглан нийгмийн оролцоогоо хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх "Иргэний хяналт" платформ хөгжүүлнэ.</p>	190.0 Урсгал зардал	Платформын тоо	0	1	<p>Ажлын даалгаврыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан. Түүнчлэн Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/93 тушаалаар Иргэн гар утас, ухаалаг төхөөрөмжөө ашиглан нийгмийн оролцоогоо хангах,</p>	80%

						хяналт тавих боломжийг бүрдүүлэх "Иргэний хяналт" платформ хөгжүүлэх ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороо байгуулагдсан. Тус тендерт оролцогчдын сонгон шалгаруулах үйл ажиллагаа явагдаж байгаа болно.	
51.	Яамны төлөвлөгөөний 72. Албан бичиг солилцооны дундын системийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Байгууллагын тоо	0	305	2025 оны эхний хагас жилийн байдлаар 2757 байгууллага албан бичиг солилцооны дундын системд холбогдсон байна. Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаартай тушаалаар байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 21 аймагт зохион байгуулж, сургалтын агуулгад албан бичиг солилцооны дундын системийн хэрэглээний талаар тусгасан. Сургалтад төрийн 3,161 албан хаагч хамрагдсан.	100%
52.	Яамны төлөвлөгөөний 73. Сонсголын бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан хиймэл	450.0 Урсгал зардал	Нэвтрүүлсэн системийн тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.30-ны өдрийн А/124 дугаар	80%

	оюуны хөрвүүлэгч систем нэвтрүүлнэ.					тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 2025.06.02-ны өдөр нээж, хянан үнэлэх ажил хийгдэж байна.	
53.	<b>Яамны төлөвлөгөөний 74.</b> Тусгай хэрэгцээт иргэдийн цахим ур чадварыг сайжруулах сургалтыг зохион байгуулна.	20.0 Урсгал зардал	Сургалтын тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.	-
54.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдэх, хөгжих эрхийг хангах ажлын хүрээнд IOS үйлдлийн системийн "Text to speech"-д Монгол хэлийг оруулах талаарх суурь судалгааг хийнэ.	-	Судалгаа хийсэн байна.	0	1	iOS үйлдлийн системд "Text to speech" (TTS)-д монгол хэлийг оруулахад шаардлагатай техникийн нөхцөл, шаардлагын судалгаа хийж iOS үйлдлийн системийн монгол хэлний TTS-г оруулахад шаардагдах техникийн даалгавар боловсруулах бэлтгэл ажлыг хэрэгжүүлж байна. Apple компаний AVSpeechSynthesizer API нь монгол хэлийг дэмждэггүй тул монгол хэлний тусгайлсан TTS систем хөгжүүлэх, уг системийг Apple компаний AVFoundation системд нэгтгэх гэсэн шат дараатай үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	50%
55.	Нээлттэй өгөгдөл, их өгөгдлийн чиглэлээр төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулна.	-	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	0	100	Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх туршилт, нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх платформыг хэрэглээнд нэвтрүүлсний дараа III-IV улиралд сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн.	-

**ХОЁР. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

2.1	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнана.	-	Боловсруулсан төлөвлөгөө, тайлангийн тоо	Төлөвлөгөө-1	Тайлан -1	Газрын бүх албан хаагч төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулан, тайлагнасан.	100%
2.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлана.	-	Архивд хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо	Хэрэгжилтээр	Хэрэгжилтээр	Тус газар, хэлтсийн албан хаагчид боловсруулсан албан бичгийн төслийг бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэнд, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, тушаалын төслийг хуулийн мэргэжилтэнд, тайлан, түүний холбогдох баримтыг тайлан хариуцсан мэргэжилтэнд тус тус тухай бүр хүлээлгэн өгч ажилласан.	100%
2.3	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ.	-	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо	Хэрэгжилтээр	Хэрэгжилтээр	Тус газар, хэлтэст 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэнийг тухай бүр шийдвэрлэн ажилласан.	100%
2.4	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс	-	ХАСХОМ бөглөх болон	Хуульд заасан хугацаанд	Хуульд заасан хугацаанд	Тус газар, хэлтсийн нийт албан хаагч ХАСХОМ бөглөх болон хуулийн хэрэгжилтийг хангаж, ажилласан болно.	100%

	урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.		хуулийн хэрэгжилтийг хангаж, ажилласан баримтын тоо				
2.5	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэх, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ.	-	Өгсөн үүрэг даалгаврын тоо	Хэрэгжилтээр	Хэрэгжилтээр	Хууль, тогтоол, тогтоол шийдвэрийн биелэлттэй холбоотой 7 үүрэг даалгавар Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр шилжин ирсэнийг тухай бүр холбогдох албан хаагчдад шилжүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%

#### ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 21. “Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд	Тоогоор	Суурь түвшин	Хүрэх түвшин	Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын албан хаагчид	Хэрэгжилтийн хувь
Худалдан авах ажиллагааны сургалтад сурч, төгссөн байна.	Амжилттай төгсөгчдийн тоо	1	6	Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын 6 албан хаагч худалдан авах ажиллагааны сургалтад сурч, төгссөн.	100%

Төрийн албаны сургууль Удирдлагын академийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдана.	Төгссөн албан хаагчдын тоо	-	2	Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын 1 албан хаагч Удирдлагын академийн богино хугацааны сургалтад, 1 албан хаагч дунд хугацааны, 1 албан хаагч урт хугацааны сургалтад хамрагдсан. (нийт 3 албан хаагч хамрагдсан.)	100%
Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдана.	Хамрагдсан албан хаагчийн тоо	1	-	Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын дарга Компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.	100%

**ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:**

ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
( Албан тушаал )

Б.БАТ-ӨЛЗИЙ / ..... /

( Нэр, гарын үсэг )

.....

( Огноо )